

Ховд аймаг дахь Төрийн аудитын салбарт хүсэлт гаргах нь

Огноо: 2020.07.24

Миний бие Жантекей овогт Хажнавий овогтой Хурманхан нь Ховд аймгийн Ховд сумын Баруун салаа багийн иргэн мөн. Ам бүл 7 аав, эхнэр, хүүхдүүдийн хамт тус сумын Дунд ус багийн төвд амьдардаг.

2020 оны орон нутгийн сонгуульд тус сумын Баруун салаа багт нэр дэвших хүсэлтэй бөгөөд орон нутгийн сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.11 дэх заалтын дагуу мөрийн хөтөлбөрөө хүргүүлж байна. Үүнд:


1. Орон нутгийн хөгжлийн санг түшиглэн уулын чиглэлийн авто замыг засварлах ажлыг зохион байгуулна.
2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх талд голлон анхаарч малчин иргэдийн хоршоо байгуулах асуудлыг уриалан зохион байгуулж ажлын байр бий болгоно.
3. Олон Улсын төслийн байгууллагуудад хандан бэлчээр ашиглалтын журмаар 1-2 худаг шинээр гаргаж иргэдийн мал услах, ундны усны хангамжийг нэмэгдүүлнэ.
4. Багийн Иргэдийн нийтийн хуралд тогтмол оролцож иргэдээс гарсан саналын дагуу багийн ажлын албадыг иргэдтэй ажиллах ажлыг улам их сайжруулна
5. Орон нутагт мөрдөгдөх эрх зүйн актыг хүний эрхийг хамгаалах, хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хуулиар оногдсон эрх үүргээ хэрэгжүүлж төрсөн нутагтаа амгалан тайван амьдрах орчинг бүрдүүлэхэд уриалан ажиллана.
6. Төр засгаас гарч буй хууль эрх зүйг хэрэгжүүлэх, сурталчлах ажилд биечлэн оролцож иргэдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлнэ.
7. Өндөр настан болон иргэдийг Эрүүл мэндийн сайдын тушаалд заасан өвчинд болон амралт сувилалд амраахад төрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлнэ.
8. Малын үүлдэр угсааг сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж махны чиглэлийн үхэр тэжээх ферм байгуулах ажлыг хөцөлдөж ажиллана.
9. Ард иргэдийн орлцоотой рашаан, булаг шандын эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг хийнэ.

Иймд зохих хуулийн дагуу шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БИЧСЭН:

БАРУУН САЛАА БАГИЙН ИРГЭН

*Хурманхан*



Х.ХУРМАНХАН